



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 10 өдөр

Дугаар Б/33

Модот

Г.Лхагважавыг ажилд томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Засгийн Газрын 2018 оны 382, 2019 оны 06, 2023 оны 240, 2024 оны 84, 238 дугаар тогтоол, Г.Лхагважавын бичгээр гаргасан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ганбатын Лхагважавыг математик, физикийн багшийн албан тушаалд 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс томилон ажиллуулсугай.
2. Г.Лхагважавын үндсэн цалинг ТҮБД-3 дугаар шатлал 1,484,000 (нэг сая дөрвөн зуун наян дөрвөн мянган) төгрөгөөр, орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар, хоолны нөхөн олговор, холбогдох бусад нэмэгдлийг зохих журмын дагуу тооцож олгохыг нягтлан бодогч (Л.Ариунтунгалаг)-т зөвшөөрсүгэй.
3. Г.Лхагважавыг мэргэжил, арга зүйгээр ханган, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүрэг, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгааг танилцуулан, хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллуулахыг сургалтын менежер (Д.Ариунаа), эд хөрөнгийг данс бүртгэлээр хүлээлгэн өгөхийг нярав (Г.Золбоо) нарт тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын багийн ахлагч (Б.Гэрэлмаа)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Д.ОТГОНДУЛАМ